


БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ТӨК-ИЙН
ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА



Техникийн нөхцөл

Дугаар: А/31

2022.09.02-ны өдөр

Захиалагч байгууллага : “ Хэнтий аймгийн засаг даргын тамгын газар”
Хэрэглэгчийн нэр: Төрийн захиргааны удирдлагын хэлтэсийн дарга Ж.Гантулга
Харилцах утас:

1.Чиглэл/Барилгын байршил: Хэнтий аймаг Батноров сумын хүрээнд

- “Цэцэрлэг”-ийн шинэ барилгыг шилэн кабелиар холбох

2.Холбооны хэрэгцээ: Шилэн кабель татах: 250 м
Төгсгөлийн төхөөрөмж: 2ш

3. Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар физик болон шилэн кабель татсан тохиолдолд тухайн барилгыг хүлээн авах техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

4. Техникийн үндсэн нөхцөл:

- 4.1 МХС-ийн байрнаас шинээр баригдах барилга хүртэл газрын хуягт 12 корийн 250 м шилэн кабелийг газраар булж барилгын оролтоор татаж оруулна.
- 4.2 /Дээрх чиглэлд шилэн кабель татахдаа техникийн нөхцлийн хайгуул буюу хавсралт хуудсанд заагдсан худаг, яндангаар кабелийг татах/
- 4.3 Шилэн кабель татахдаа худагт нөөц үлдээхгүй бөгөөд төгсгөлийн төхөөрөмж байрлуулах байрлалд нөөцийг авах шаардлагатай.
- 4.4 Техникийн нөхцлийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэж техникийн актыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд тухайн чиглэлийн худаг сувагчлалыг шилжүүлэх, гадны гэмтэл саатал гарсан тохиолдолд гарах зардал болон хариуцлагыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК хариуцахгүй болно.
- 4.5 Харилцаа холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.
- 4.6 Захиалагч шинээр хийгдэж буй худаг сувагчлалд газрын зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байна.

5. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 5.1 Шинээр хийгдэх кабель, шугам болон худаг сувагчлалын угсралтын ажлын зураг төсвийг зохиоходоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS

5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ны сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх

5.2 Кабель татах трассын зураг гаргахдаа шаардлагатай худагт кабелийн болон муфтын тавиур хийх ажлыг тусгаж өгөх

6 Угсралтын ажлын үед тавигдах нөхцлүүд:

6.1 Шинээр татсан кабельд бирк бүрэн хийсэн байх ба шилэн кабель татах тохиолдолд хамгаалалтын уян хоолойг худагт хийж өгөх, худагт муфть хийх бол худгийн хананд тусгай тавиур хийх, худаг бүрт кабелийн бирк зүүсэн байх

6.2 Угсралтын ажлын явцад захиалагч, ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх

6.3 Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах ШКХ-т (утас:70562225, 99055625, 98619051) мэдэгдэж кабель татах янданг заалгаж түүний дагуу гүйцэтгэх ба гүйцэтгэлийг КТБХТ-н паспортжуулалтаар хянуулан актанд тусгуулна. Хэрэв заагдсан яндангаар татаагүй нөхцөлд ашиглалтын явцад шилжүүлэх шаардлага гарвал гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.

7 Техникийн нөхцлийг "Хэнтий аймгийн ЗДТГ-н төрийн захиргааны удирдлагын хэлтэсийн дарга Ж.Гантулга"-ын 2022 оны 08 сарын 31-ний өдрийн 1/2020 тоот хүсэлтийг үндэслэн 2022 оны 09 сарын 02 ны өдөр олгов.

8 Угсралтын ажил дууссаны дараа АВТОСАД –н зураг, кабель татсан яндангийн паспорт техникийн актыг тухайн МХС-ний газарт хүлээлгэн өгөх шаардлагатай

9 Энэхүү техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙГ ХЯНАСАН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:  Т.БАЯРМАА

ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙГ БОЛОВСРУУЛСАН:

КШ-ИЙН ИНЖЕНЕР:  Г.НОМИН-ЭРДЭНЭ

БАТЛАВ
БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ Н.МӨНГӨНХӨЛӨГТ



2022 оны 05 дугаар сарын 16

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

- 2022 оны 05 дугаар сарын 13 №ХЭ 22/22 Багануур дүүрэг
1. Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд: Хэнтий аймаг, Батноров сумын засаг дарга
 2. Хэрэглэгчийн хаяг: Хэнтий аймаг, Батноров сум, 6-р баг
Утас: 93151015
 3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл: Хэнтий аймаг, Батноров сум, 6-р баг, Жавхлант 101А
3-р зэрэглэл
 4. Ажил үйлчилгээний зориулалт: 200 хүүхдийн цэцэрлэгийн гадна цахилгаан хангамж
 5. Техникийн нөхцөл олгох үндэслэл: 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 101 тоот албан бичиг
 6. Хэрэглээний нийт чадал: 50 кВт
 7. Холбогдох цэг:
 - 7.1 35/10 кВ Батноров дэд станц 10 кВ-ын Сумын төв гаргалгаанаас тэжээлтэй АТП-71 дэд өртөөний 100 кВА чадалтай 10/0.4 кВ-ын хүчний трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлж, 250 кВА чадалтай 10/0.4 кВ-ын хүчний трансформатор шинээр суурилуулна.
 - 7.2 АТП-71 дэд өртөөний 0.4 кВ-ын хуваарилах самбарын оруулгын кабель шугамыг ачаалалдаа тохирсон хөндлөн огтлолын талбайтай кабель шугамаар шинэчилнэ.
 - 7.3 Хүчин чадал нэмэгдүүлсэн 10/0.4 кВ-ын дэд өртөөний 0.4 кВ талаас ачаалалдаа тохирсон хөндлөн огтлолтой газарт булах зориулалт бүхий цахилгаан дамжуулах кабель татаж "Цэцэрлэг"-ийг цахилгаан эрчим хүчээр хангана.

2000 ОНД
ХЭНГИЙН

Төвдөг үүрэг.

9.8 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай хэмжилт туршилтыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

9.9 Хэрэглэгч нь 35/10 кВ-ын Батноров дэд станц Сумын төв гаргалгааны реле хамгаалалтын тавилын тооцоог БЗӨБЦТС ТӨХК-иар хийлгэнэ.

9.10 Хэрэглэгч нь 35/10 кВ-ын Батноров дэд станц Сумын төв гаргалгааны ачааллыг тооцож, шаардлагатай тохиолдолд гүйдлийн трансформаторыг солино.

9.11 Тухайн хэрэглэгч нь түгээх сүлжээнд холбогдсон нөхцөлд цахилгааны хэрэглээ, цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллагаа нь түгээх сүлжээний үндсэн параметр болох хүчдэл, давтамжийн утганд нөлөөлж нэгдсэн сүлжээний дүрмэнд заасан зөвшөөрөгдөх утгаас хэлбэлзэх, огцом буурах, өсөх, тоноглолын ачаалагдах хэмжээ зөвшөөрөгдөх хязгаараас давах мөн байгалийн онц ноцтой хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн түгээх сүлжээний үйл ажиллагаа доголдох, саатах нөхцөл байдал үүссэн тохиолдолд түгээх сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангахын тулд хугацаа харгалзахгүй цахилгаан эрчим хүчээр хязгаарлах, түдгэлзүүлэх нөхцөлөөр холбогдоно.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 3.1-3.5 дугаар заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтад хүлээн авах журам"-ын дагуу холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.4, 30.1.7, 30.1.8 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд Шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Хэрэглэгч нь "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн заалтуудыг баримталж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

10.8 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана.

2.17 Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1 Хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2 Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3 Холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн.

10.9 Техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан IEC 61861-1 стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, RS-485 болон GSM /3G, 4G/-р гадны төхөөрөмжтэй холбогдох боломжтой IEC 62053 стандартын шаардлага хангасан 0.2S нарийвчлалтай, санах ойтой, олон үйлдэлтэй 5 А-ын ухаалаг тоолуур суурилуулна.

9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр угсрах 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөөний ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, техникийн нөхцөл олгогчоор хянуулж, магадлан хяналтаар баталгаажуулна.

9.2 Шинээр угсрах 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын трассын зураг, схемийг Хэнтий ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 Хүчин чадал нэмэгдүүлсэн 10/0.4 кВ-ын дэд өртөөний газардуулгын байгууламжийн тооцоог хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэж, "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн дагуу газардуулга хийнэ.

9.4 Шинээр угсрах 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөө нь бусдын эзэмшлийн газар, инженерийн байгууламжийг огтлолцож байгаа цэгүүдэд холбогдох эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл авна.

9.5 Хэнтий аймгийн газрын албанаас 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын трассын дагуу газрын зөвшөөрөл авч баталгаажуулан мэдээллийн нэгдсэн санд оруулна.

9.6 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшингийн $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, байгаль экологид сөрөг нөлөөлөлгүй, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж суурилуулна.

9.7 Шинээр угсрах 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай

10.10 Техникийн нөхцөлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн түгээх сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

ХЯНАСАН:

ТҮАХТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР

ТҮАХБ ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ТҮАХБ ХЭЛТСИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
ХАРИУЦСАН ИНЖЕНЕР

А.АЗБАЯР

Б.ТӨМӨРХУЯГ

Л.МӨНХ-ЭРДЭНЭ